

ТАНИЛЦУУЛГА

“Тогтоолд нэмэлт оруулах тухай”
Улсын Их Хурлын тогтоолын төслийн тухай

Өмнөговь аймгийн Гурвантэс сумын нутаг дэвсгэр дэх Нарийнсухайтын орд газар 800 орчим сая тонн коксжих болон эрчим хүчний нүүрсний батлагдсан нөөцтэй, техник-эдийн засгийн үндэслэлийн судалгаагаар нийт хүчин чадал нь жилд 33.5 сая тонн гэж тогтоогдсон. Энэ ордод 2015 оны байдлаар нийт ашигт малтмалын 68 тусгай зөвшөөрөл олгогдсоноос 16 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй 6 компани нүүрсний олборлолт, экспортын үйл ажиллагаа эрхэлж байна.

Нарийнсухайтын орд газраас Шивээхүрэнгийн боомтоор дамжин БНХАУ-ын хилийн Сэхэ боомт хүрдэг хүнд даацын авто замын боомтын нэвтрүүлэх хүчин чадал 10-12 сая тонн бөгөөд 2016 онд тус боомтоор нийт 11.9 сая тонн нүүрс экспортолж, гаалийн мэдүүлгийн дүнгээр 310.9 сая ам.долларын орлого олсон байна.

Хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлаас шалтгаалан нүүрсний экспортын өнөөгийн түвшинг нэмэгдүүлэх боломжгүй байгаа төдийгүй тээврийн зардал, логистикийн олон шат дамжлагаас шалтгаалж уул уурхайн бүтээгдэхүүн хямд үнээр борлуулагдаж байна.

Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 46.2 км төмөр замын суурь бүтцийг барьж байгуулах тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон бөгөөд тус чиглэлийн төмөр замын ТЭЗҮ болон зураг төслийг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар товчоо боловсруулсан.

Төсөл хэрэгжүүлэх хугацаа	2017-2019
Төмөр замын урт /км/	46.2
Суурь бүтцийн хүчин чадал /сая тонн/	21.0
Төслийн өртөг /сая ам.доллар/	144.7
Эргэн төлөгдөх хугацаа /жил/	8.4
Дотоод өгөөжийн түвшин-IRR	16 хувь

Нарийнсухайт-Шивээхүрэнгийн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барьж байгуулснаар Нарийнсухайтын орд газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг төмөр замаар тээвэрлэж экспортлох шинэ гарц нээгдэж, манай улсын нүүрсний экспортын зах зээл тэлж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 3 дахин нэмэгдэж, тээврийн өртөг 2-4 дахин буурч, хүрээлэн буй орчин ба аюулгүй ажиллагааны нөхцөл сайжрах юм.

Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг 1520 мм-ийн царигтайгаар барьж байгуулбал БНХАУ-ын 1435 мм-ийн царигтай төмөр замын сүлжээтэй холбогдохын тулд шилжүүлэн ачих байгууламжийг ачаа хүлээн авах талд барьж, тонн тутамд 3-5 ам.долларын нэмэлт зардал гарна.

Мөн Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 46.2 км төмөр замын тээврийн зардал ойролцоогоор 1.5-2.0 ам.доллар, шилжүүлэн ачих байгууламж барьж

байгуулснаар логистикийн нийт өртөг 6-8 ам.доллар болж нэмэгдэн, тээврийн зардал харьцангуй өсөх болно.

Ингэснээр уул уурхайн салбараас манай улсын эдийн засагт орох 100 орчим сая ам.долларын орлого алдагдах төдийгүй төсөл хэрэгжүүлэгч нь 1520 мм-ийн царигтай төмөр замын суурь бүтцэд ашиглах 500 ширхэг ачааны вагон буюу 40.0 сая ам.долларын нэмэлт хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх шаардлага үүсэх юм.

**Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хүнд даацын авто зам
ба төмөр замын тээврийн өртгийн харьцуулалт /тонн/**

Үзүүлэлт	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн хүнд даацын авто зам	Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам
Бичиг баримт бүрдүүлэлт	4.55 ам.доллар	1.85 ам.доллар
Боомтын нэвтрүүлэх дээд хүчин чадал	10.0-12.0 сая тонн	25.0-30.0 сая тонн

Царигийн харьцуулалт

Тодорхойлолт	1520 мм-ийн цариг	1435 мм-ийн цариг
Шилжүүлэн ачилтын өртөг /тонн тутам/	3.0-5.0 ам.доллар	-
Шилжүүлэн ачилтын хугацаа	2-6 цаг	-
500 ширхэг ачааны вагон	40.0 сая ам.доллар	Хүлээн авагч талын вагоноор тээвэрлэнэ.
Байгаль орчны бохирдол	Тоосжилт, шатах тослох материалын бохирдол үүснэ.	-
Ачааны хорогдол /хувь/	1-2	0

Иймд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг 1435 мм-ийн царигтайгаар барьж байгуулснаар БНХАУ-ын эцсийн хэрэглэгчид уул уурхайн бүтээгдэхүүнийг шууд хүргэх, тус улсын төмөр замаар дамжин гуравдагч зах зээлд хүрч экспортын шинэ гарцыг бий болгох зорилгоор тус чиглэлийн төмөр замын царигийн өргөний хэмжээг тогтоолгохоор Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР